

## ХОРИГДЛЫН ЗҮГЭЭС ҮЙЛДЭЖ БОЛЗОШГҮЙ НИЙТИЙГ ХАМАРСАН ЭМХ ЗАМБАРААГҮЙ БАЙДАЛ ТҮҮНИЙ ОНЦЛОГ

### INTERNATIONAL STANDARDS FOR THE EXECUTION OF IMPRISONMENT



#### 3.Түвшинжаргал

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн  
Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын  
тэнхимийн багш, хууль зүйн магистр, ахмад*

**Товч утга:** Хоригдлын зүгээс нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гаргасан үед ажиллах арга ажиллагааны бэлэн байдал, техник хэрэгсэл, хүн нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийн хүртээмж, сургалтыг сайжруулахад чиглэгдэнэ.

**Түлхүүр үгс:** Хорих анги, хоригдол, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, хүн нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл.

**Abstract:** The article aimed to improve the training for the readiness of working methods and the sufficiency of non - lethal weapon that can affect each person or public in case insurgence, occurs by prisoners.

**Keywords:** prison, prisoner, insurgence, weapons that can affect each person or public.

Нийгэм, эдийн засгийн болон амьдралын хэв маягийн өөрчлөлтэй уялдан Монголын нийгмийн амьдралд эерэг, сөрөг олон шинэ үзэгдэл бий болж үүнтэй холбоотойгоор гэмт хэрэг үйлдэж байгаа нөхцөл байдал, арга хэрэгсэл, хэв маягт ч өөрчлөлт гарсан.

Монгол улсын Үндсэн хуульд Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн гэж хуульчилсан.

Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон гэм буруутай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, үүнээс гадна хорих ял шийтгүүлсэн хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдүүлэхгүй байх чиг үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага буюу хорих анги хүлээдэг билээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн гэж хуульчилсан байдаг. Энэхүү тусгайлсан чиг үүргийнхээ хүрээнд эрүү, иргэн, захиргааны шүүхээс гаргасан бүхий л төрлийн шийдвэрийг гүйцэтгэдэг ба хоригдлын зүгээс гэмт хэрэг дахин гаргуулахгүй байх үүргийг хорих анги хариуцан зохион байгуулан ажиллаж байна.

Хорих ял эдэлж байгаа хоригдлын зүгээс гэмт хэрэг дахин үйлдэх буюу нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гаргаж болзошгүй өдөөн хатгалга, бусдыг энэ үйлдэлд турхирах үйлдэл гаргасаар ирсэн.

Иймд нийтийг хамарсан эмх замбараагүй байдал буюу онцгой учралын үед ажиллах бэлэн байдлыг хангуулах төлөвлөгөөг тодотгох, техник хэрэгсэл, хүн нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг нэмэгдүүлэх, сургалт дадлагыг тогтмолжуулах, арга тактикт алба хаагчдыг сургах шаардлагатай.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гэж юу вэ?

Янз бүрийн хүмүүс олноороо цугларах, цуглаан зохион байгуулах зорилго өөрчлөгдөн жижиг үймээн самуун, олныг хамарсан эсэргүүцэл, бослого, зэрлэг балмад үйл ажиллагаа /эвдэх, шатаах, дээрэмдэх г.м./ үүссэн нөхцөл байдлыг ойлгоно.

Энэ нь төрийн тусгай чиг үүргийн байгууллагад онцгой хүндрэл учруулдаг. Цуглааны төлөв, цуглаанд оролцогсдын зан байдлыг ойлгох нь авч хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой тодорхойлох, хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй.

Олон нийтийн эмх замбараагүй байдал үүссэн нөхцөл байдалд оролцсон хүмүүс дараах 3 үе шатыг дамждаг:

- 1) хувь хүний чанараа алдаж олон нийтийн нөлөөнд автах,
- 2) өөрөө шийдвэр гаргах чадваргүй болж, олны урсгалд татагдан орох,
- 3) эргэн тойрны олон түмний нөлөө /шуугиан/ ихсэх үед сэтгэл зүйн хувьд тэдний уур амьсгалд уусан орох.

Монгол Улсад гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх ажлыг хэлбэрэлтгүй бэхжүүлж, хэрэгжүүлэх нь өнөөгийн нийгмийн хөгжлийн зүй тогтлын чухал зорилт болоод байна.

Олон нийтийн аюулгүй байдал нь байгалийн гамшиг, гэнэтийн бусад осол болон зарим байгууллага хүмүүс хүрээлэн байгаа орчиндоо эд зүйл, механизмтай

зүй бус харьцанаас хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөд учирч болох хор хөнөөлийг арилгах, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх зорилготой.

Монгол Улсын хэмжээнд хорих ял эдлүүлэх чиг үүрэг бүхий 51 орчим нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулиар олгогдсон эрх хэмжээ, чиг үүргийнхээ хүрээнд “Хоригдлын аюулгүй байдлыг хангаж, тэдний дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, хоригдол бусад этгээдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх” чиг үүргийг хэрэгжүүлсээр ирсэн билээ.

Энэ үүргийн хүрээнд хорих байгууллагад үүсэж болзошгүй онцгой нөхцөл байдлын нэг хэсэг болсон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал нь нийгмийн аюулт үзэгдлийн нэг юм.

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх газарт нийтийг хамарсан эмх замбараагүй байдал нь дараах хэлбэрээр илрэн гарч болно. Үүнд:

Хоригдлууд хэсэг бүлгээрээ нийлж өлсгөлөн зарлах, суулт зохион байгуулах

Нөлөө бүхий хоригдлууд хоорондоо хагаралдан зөрчил үүсгэх, уг зөрчил нь олон нийтийг хамарсан шинжтэй болох

Олны танил болон дуулиант хэрэг үйлдэж шийтгүүлсэн хоригдлыг суллах зорилгоор хорих ангийн харуул хамгаалалтын хэвийн үйл ажиллагааг алдагдуулж гаднаас халдах, жагсаал цуглаан зохион байгуулах

Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан үед

Монгол улсад хорих ял эдлүүлэх ажиллагааны түүхэн цаг хугацааны явцад хоригдлын дундаас онц ноцтой гэмт хэрэг үйлдэх, нийтийг хамарсан суулт, зэвсэгт халдлага зэрэг ноцтой хэрэг, учрал гарч олон хүний амь нас, бие эрхтэнд хор хохирол учруулж байсан гашуун сургамжууд бий.

Тухайлбал: Авдрант дахь хорих 403 дугаар ангийн онцгой дэглэмтэй 80 орчим хоригдол зохион байгуулалттайгаар “Онцгой дэглэмтэй ялтнууд хуулийн тэгшитгэлд хамрагдаагүй. Энэ асуудлыг шийдэж өгөх хүртэл суултаа дуусгахгүй” гэх шаардлага тавин 1990 онд суулт зохион байгуулсан байдаг.

Мөн 2009 онд “Өршөөл үзүүлэх тухай хууль” гарсны дараа буюу 2009 оны 07 дугаар сарын 24-ний өдөр Булган аймаг дахь онцгой дэглэмтэй хорих 439 дүгээр ангийн 60 гаран хоригдол “Өршөөлийн хуульд хамрагдаагүй, цаашид хамруулж өгтөл суулт хийнэ” гэсэн шаардлагыг тавин суулт хийсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хорих анги, шийдвэр гүйцэтгэх газрын даргын баталсан “Онцгой учралын үед ажиллах төлөвлөгөө”-г хэрэгжүүлэн ажиллаж байгаа ба хорих анги, газрын алба хаагчид төлөвлөгөөнд

тусгагдсан үйл ажиллагааг дэс дараалалтай хийж гүйцэтгэх бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас томилогдсон тусгай бүлгийн алба хаагчид очих хүртэл үйл ажиллагааг тухайн хорих ангийн дарга удирдан зохион байгуулах, төрийн тусгай чиг үүргийн байгууллага буюу орон нутгийн цэрэг, онцгой, цагдаагийн байгууллагуудтай хамтран ажилладаг байна.

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх газарт ял эдэлж буй хоригдлын зүгээс нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болгосон, үймээн самуун, хорих байгууллагын ажилтан, албан хаагчдыг барьцаанд авсан зэрэг “Онцгой нөхцөл байдал”-ын үед хорих анги, шийдвэр гүйцэтгэх газрууд нь өөрийн хүч, хэрэгслээр таслан зогсоох боломж, нөхцөл бий эсэхийг судалж үзэв.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хорих ангид нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон онцгой тохиолдолд хорих ангид харуул хамгаалалтыг байнгын хамгаалалт, өндөржүүлсэн бэлэн байдал, хүч нэмэгдүүлсэн хамгаалалт гэсэн гурван төрлөөр зохион байгуулахаар зохицуулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хорих анги, газрын харуул хамгаалалтад ямар нэгэн байдлаар гаднаас халдсан, онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн хорих ангид түүнийг зогсоох хүч хэрэгсэл байхгүй, зөвхөн ээлжийн бүрэлдэхүүн үүрэг гүйцэтгэхээс гадна “Онцгой учралын үед ажиллах төлөвлөгөө”-ний хүрээнд “Тусгай томилгоот бүлэг” бэлэн байдлыг ханган ажилладаг байна.

Хорих анги, салбар байгууллагад үүсэж болзошгүй нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын гол субъектийн онцлог нь:

Гэмт хэрэг үйлдэн хорих ялаар шийтгүүлж нийгмээс тусгаарлагдсан хүн байдаг

Дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй

Бусдын нөлөөнд автах магадлал амархан зэрэг онцлогтой хүмүүс байдаг.

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх газрын “Онцгой учралын үед ажиллах төлөвлөгөө”-ний зохион байгуулалт, хэрэгжилтийг тандах зорилгоор арван байгууллагын хамгаалалтын ажилтан нараас судалгааг авсан юм.

Судалгаанд хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, баривчлах байрны 36 албан хаагч хамрагдсан бөгөөд судалгааны асуулгад дараах байдлаар хариулсан байна.

Судалгаанд оролцогчдын 18 буюу 50 хувь нь “Онцгой учралын үед ажиллах төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхэд хүндрэлтэй гэж хариулсан. Тусгай хэрэгслийн хүрэлцээ ямар байдаг вэ? гэсэн асуултад 32 буюу 88,8 хувь нь хангалтгүй, дутагдалтай гэж хариулсан. Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл бий

юу? гэсэн асуултад 22 буюу 61 хувь нь байхгүй гэж хариулсан. Онцгой учралын үед ажиллах, тусгай хэрэгсэл хэрхэн хэрэглэх талаарх давтан сургалт болдог уу? гэсэн асуултад 14 буюу 39 хувь нь үгүй гэж хариулсан. Тусгай томилгоот бүлэгт ажиллахад нэмэгдэл цалин, урамшуулал, нийгмийн баталгаа олгодог? гэсэн асуултад 36 буюу 100 хувь үгүй гэсэн хариултыг тус тус өгсөн байна.

Судалгаанд оролцогчид нь “Тусгай томилгоот бүлэг”-т ажиллах нь үүрэг, хариуцлага нэмэхээс өөр ямар ч нэмэгдэл цалин, хөлс олгодоггүй, тусгай хэрэгсэл хэрэглэх давтан болон төрийн тусгай чиг үүргийн байгууллагатай хамтарсан сургалт хийх нь маш бага байдаг гэх зүйлсийг дурджээ.

Энэ талаар зохион байгуулалтын арга хэмжээг удирдлагаас авч ажиллахгүй бол алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс хамгаалах, эрсдэлийг бууруулах, тэдэнд хохирол учрахаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

### Дүгнэлт

Хорих, цагдан хорих үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хорих байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдахуйц онцгой нөхцөл байдал, гадны болон дотоод ноцтой халдлага өмнө гарч байсан, цаашид ч гарч болзошгүй нөхцөл байдал ямагт байсаар байна.

Болзошгүй эрсдэл үүссэн үед энэхүү үйл ажиллагааг таслан зогсооход тусгай зэвсэглэсэн, бэлтгэгдсэн хүч зайлшгүй хэрэгтэй юм.

Энэ талаар зохион байгуулалтын арга хэмжээг удирдлагаас авч ажиллах, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс хамгаалах, эрсдэлийг бууруулах урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг авч ажиллахгүй бол алба хаагчийн аюулгүй байдлыг ханган ажиллахад сөрөг нөлөөг үзүүлж байна.

Төрөөс алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хамгаалах чиг үүрэгтэй. Гэтэл энэ үүрэг нь бодит амьдрал дээр биеллээ олохгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

### Санал

1. Хорих байгууллагад бий болсон онцгой учралын үед ажиллах “Тусгай томилгоот бүлгүүд”-ийн нийгмийн баталгаа, цалин, урамшууллыг эрх зүйн актад тодорхой тусгаж өгөх.

2. Тусгай томилгоот бүлгийн албан хаагчийг бэлтгэх, давтан сургах, туршлага солилцох, сургалтын материаллаг баазыг бий болгох.

3. Тусгай бүлгийн албан хаагчийн үүрэг гүйцэтгэхэд зайлшгүй шаардагдах тусгай ажиллагааны хувцас, хамгаалах хэрэглэл, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийн хангалтыг стандартын түвшинд хүргэх.

4. Гадаад орнуудын хорих байгууллагын Тусгай бүлгийн алба хаагчдын хэрэглэдэг хүний амь насанд аюулгүй, аминд халгүй тусгай хэрэгсэл, багажийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зэрэг саналыг дэвшүүлж байна.

**Ашигласан эх сурвалжийн жагсаалт:**

1. Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992
2. Эрүүгийн хууль. УБ., 2015
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017. №24
4. Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэн, Цагдаагийн шинжлэх ухааны зарим нэр томъёоны гарын авлага. УБ., 2017

---o0o---